



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ

**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР**

Засгийн газрын IX байр, Энхтайваны өргөн чөлөө 16,

Баянзүрх дүүрэг, Улаанбаатар хот, 13381

Утас: (976-51) 26 23 50,

Цахим шуудан: info@pcsp.gov.mn,

Цахим хуудас: www.pcsp.gov.mn

2026.08.07 № А1/1367
танай _____-ны № _____-т

**Төрийн болон орон нутгийн
өмчийн талаар авч хэрэгжүүлэх
арга хэмжээний тухай**

Засгийн газрын хуралдаанаар төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байр талбайн ашиглалт, түрээсийн нөхцөл байдлын талаар хэлэлцээд Засгийн газрын 2026 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн хуралдааны 17, 7 дугаар сарын 08-ны өдрийн хуралдааны 28 дугаар тэмдэглэлээр тодорхой үүрэг чиглэлүүдийг өгсөн.

Иймд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэх шаардлагатай байна. Үүнд:


1. Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжид өөрийн эзэмшлийн байргүй, төрийн байгууллагыг ашиглалтын зардлаар нь байршуулах асуудлыг шийдвэрлэх
2. Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байр, талбайг хэт бага үнээр түрээслүүлж байгаа асуудлыг нягталж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах арга хэмжээ авах,
3. Төсвийн болон төрийн өмчийн өмч хөрөнгөөр шинээр оффис, конторын зориулалттай төрийн өмчийн байр худалдан авахыг 2026 оны 7 дугаар сарын 20-ны өдрөөс эхлэн зогсоох
4. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон албан тасалгааны зориулалтаар байр, талбай түрээслэх жишиг үнийн хязгаараас давсан үнийн дүн бүхий түрээсийн гэрээг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор дуусгавар болгох, түүнээс өмнө дуусах гэрээг сунгахгүй байх, шинээр түрээсийн гэрээ, дамжуулан түрээслэх гэрээ болон түрээсийн гэрээний зэрэгцээ менежмент, ашиглалт, үйлчилгээний нэрээр давхар гэрээ байгуулахгүй байх
5. Төрийн өмчийн барилга байгууламж, байр талбайн бүртгэл, ашиглалтын зөрүүтэй байдлыг арилгаж, тогтмол хяналт тавих, сул талбайн мэдээллийг нээлттэй ашиглахад чиглэсэн "Төрийн өмчийн цахим бүртгэл, удирдлагын нэгдсэн систем"-байгууллагын хөрөнгийг бүртгэх, эзэмшил, ашиглалттай холбоотой мэдээ мэдээллийг цаг тухайд нь үнэн зөв оруулан баталгаажуулах,

Албан тасалгааны зориулалтаар байр, талбай түрээслэх тогтоосон хязгаар зөрчиж, гэрээ байгуулсан төсөвт байгууллагын удирдлага, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын гүйцэтгэх удирдлагад холбогдох хууль, тогтоомжийн дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авахыг мэдэгдье.

132003679

A-4/2026

Засгийн газрын шийдвэрийг хэрэгжүүлэн ажиллаж, үр дүнг Төрийн болон орон нутгийн өмчийн нэгдсэн мэдээллийн системд оруулж, тайланг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны дотор ирүүлэхийг хүсье.

ДАРГА  Б.ЦЭНГЭЛ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

САНГИЙН ЯАМ, ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗАР,
АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАРТ

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 05 дугаар сарын 06-ны өдрийн
17 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"12.6.Төрийн өөрийн өмчийн байр, талбайн ашиглалт, түрээсийн гэрээний
хэрэгжилтийн нөхцөл байдлын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга Б.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан
Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнуудад даалгав:

1.Өөрийн эзэмшлийн байргүй төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн
этгээдийг үндсэн үйл ажиллагааны чиглэл, орон тоо, чиг үүрэгтэй нь уялдуулан
суларсан, ашиглалтгүй байгаа төрийн өмчийн барилга, байр, талбайд байршуулах
боломжийг судалж, холбогдох Засгийн газрын гишүүдээс санал авч, 2026 оны
05 дугаар сарын 08-ны өдөр Монгол Улсын Ерөнхий сайдад танилцуулан чиглэл авч
ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;

2.Төрийн болон орон нутгийн өмчийн барилга байгууламжид өөрийн
эзэмшлийн байргүй төрийн байгууллагыг ашиглалтын зардлаар нь байршуулах
асуудлыг 2026 оны 3 дугаар улиралд багтаан шийдвэрлэхийг Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого,
зохицуулалтын газар (Б.Цэнгэл), аймаг, нийслэлийн Засаг дарга нарт;

3.Төрийн болон орон нутгийн өмчийн барилга, байр, талбайг хэт бага үнээр
түрээслүүлж байгаа асуудлыг нягталж, шаардлагатай тохиолдолд гэрээг цуцлах
арга хэмжээ авах, түрээсийн жишиг доод үнийг зах зээлийн жишигт нийцүүлэн
шинэчлэхийг Сангийн сайд З.Мэндсайхан, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газар (Б.Цэнгэл)-т;

4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон албан
тасалгааны зориулалтаар байр, талбай түрээслэх жишиг үнийг мөрдүүлэх, үндсэн
үйл ажиллагааны зорилго, чиглэлд хамаарахгүй зориулалтаар байр, талбай
түрээслэхийг хязгаарлах, төсөв хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах байдлыг
таслан зогсоох зорилгоор хяналт, шалгалт хийх арга хэмжээ авахыг Төрийн өмчийн
бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т." гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

Наранцруу
5/12
2026

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

ЗАСГИЙН ГАЗРЫН ГИШҮҮД, ЗАСГИЙН ГАЗРЫН АГЕНТЛАГИЙН
ДАРГА НАР, АЙМАГ, НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР,
"ЧИНГИС ХААН БАЯЛГИЙН САН НЭГДЭЛ" ХХК-д

Монгол Улсын Засгийн газрын 2026 оны 07 дугаар сарын 08-ны өдрийн
28 дугаар хуралдааны тэмдэглэлд:

"31.7.Төрийн өмчийн байр, талбайн ашиглалт, түрээсийн гэрээний
хэрэгжилтийн явцын талаар Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх
газрын дарга Б.Энхбаяр Засгийн газрын гишүүдэд танилцуулав.

Үүнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг доор дурдсан
Засгийн газрын гишүүд, холбогдох албан тушаалтнуудад даалгав:

1.Төсвийн болон төрийн өмчийн хөрөнгөөр шинээр оффис, конторын
зориулалттай төрийн өмчийн байр худалдаж авахыг 2026 оны 07 дугаар сарын
20-ны өдрөөс эхлэн зогсоохыг бүх шатны төсвийн захирагч, төрийн болон орон
нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга, захирал, төлөөлөн удирдах зөвлөлд;

2.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас тогтоосон албан
тасалгааны зориулалтаар байр, талбай түрээслэх жишиг үнийн хязгаараас давсан
үнийн дүн бүхий түрээсийн гэрээг 2026 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор
дуусгавар болгох, түүнээс өмнө дуусах гэрээг сунгахгүй байх, шинээр түрээсийн
гэрээ, дамжуулан түрээслэх гэрээ болон түрээсийн гэрээний зэрэгцээ менежмент,
ашиглалт, үйлчилгээний нэрээр давхар гэрээ байгуулахгүй байхыг бүх шатны
төсвийн захирагч, төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдийн дарга,
захирал, төлөөлөн удирдах зөвлөлд;

3.Албан тасалгааны зориулалтаар байр, талбай түрээслэх тогтоосон хязгаар
зөрчиж, гэрээ байгуулсан төсөвт байгууллагын удирдлага, төрийн болон орон
нутгийн өмчит байгууллагын гүйцэтгэх удирдлагад холбогдох хууль тогтоомжийн
дагуу хариуцлага тооцох арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын
Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын
газар (Б.Цэнгэл)-т тус тус;

4.Улсын төсвийн зардлыг хэмнэх, төрийн өмчийн удирдлагын үр ашгийг
дээшлүүлэх зорилгоор төрийн өмчийн байр, талбайн ашиглалтын нэгдсэн
судалгааны дүнд тулгуурлан төрийн албан хаагчийн ажлын байрны талбайн
норматив хэмжээ, нэг ажилтанд ногдох талбайн стандарт болон төсөвт байгууллага,
төрийн өмчит хуулийн этгээдийн албан ажлын өрөө, талбайн хэмжээний нийтлэг
жишиг болон "Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгө түрээслэх журам"-ыг шинэчлэн
батлуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга
Б.Энхбаяр, Хот байгуулалт, барилга, орон сууцжуулалтын сайд Э.Бат-Амгалан,
Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус;

Д. Нарангорал
Э.маа *Эн/ау/у*

5.Шүүхийн байгууллагуудын үйл ажиллагааг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэх хүрээнд шүүх хуралдааны танхим, ажлын байрны хүрэлцээгүй нөхцөл байдлыг шуурхай судалж, нэн тэргүүнд байр, талбай хуваарилах арга хэмжээ авахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус;

6.Төрийн өмчийн байр, талбайн ашиглалтын нэгдсэн судалгааны дүнгээр тогтоогдсон илүүдэл болон үр ашиггүй ашиглагдаж байгаа байр, талбайд болон Шинжлэх ухааны академийн харьяа хүрээлэнгүүдийн суларсан байр, талбайд хувийн хэвшлийн байранд түрээсээр байрлаж байгаа төрийн байгууллага, төрийн өмчит хуулийн этгээдийг шилжүүлэн байршуулах зардлыг нарийвчлан тооцож, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус;

7.Төрийн өмчийн барилга байгууламж, байр, талбайн бүртгэл, ашиглалтын зөрүүтэй байдлыг арилгаж, тогтмол хяналт тавих, сул талбайн мэдээллийг нээлттэй ашиглахад чиглэсэн “Төрийн өмчийн цахим бүртгэл, удирдлагын нэгдсэн систем”-ийг ашиглалтад оруулж, төрийн болон орон нутгийн өмчит байгууллагын хөрөнгийг бүртгэх арга хэмжээг шуурхай зохион байгуулахыг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т;

8.Төрийн өмчит хуулийн этгээдийн хувьцааг 2026-2028 онд биржээр олон нийтэд нээлттэй худалдах, төрийн өмчийг хувьчлах, өөрчлөн байгуулах үндсэн чиглэлийг боловсруулж, 2026 оны 08 дугаар сард Засгийн газрын хуралдаанд танилцуулахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус;

9.Төрийн өмчит компанийн талаар баримтлах үндсэн чиглэлийн төслийг боловсруулж, 2026 оны 4 дүгээр улиралд багтаан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэхийг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Б.Энхбаяр, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газар (Б.Цэнгэл)-т тус тус.” гэжээ.

ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР